

## ӨМНӨХ ҮГ

Шинжлэх ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Монголын ботаникийн сэтгүүл”-ийн ээлжит 04 (30) дугаар хэвлэгдэн уншигч та бүхний гар дээр очиж байна.

Тус сэтгүүл нь уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даацын хэтрэлт, уул уурхай, зам тээврийн эрчимтэй хөгжил зэрэг абиотик болон биотик хүчин зүйлүүдийн нөлөөгөөр ургамлан нөмрөг доройтож хэмжээ нэмэгдэж байгаа өнөө үед элсний нүүдлийг сааруулах, цөлжилтийг бууруулах, ургамлын нөөцийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд төр засгаас ихээхэн анхаарал хандуулан боловсруулсан “Алсын хараа 2050”, “Шинэ эргэлтийн бодлого”-д тусгагдсан Ногоон хөгжлийн сэргэлтийн тухай заалтууд, “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд хийгдэж буй туршилт судалгааны үр дүнгүүдийг олон нийтэд түгээн дэлгэрүүлж байна.

“Монголын Ботаникийн сэтгүүл” нь ургамал судлалын шинжлэх ухааны бүхий л чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авч хөндлөнгийн 2 шинжээчээр шүүмж хийлгэн хэвлүүлдэг. Энэ дугаараас эхлэн “Монголын Ботаникийн сэтгүүл” нь Монголын цахим сэтгүүлүүдийн нэгдсэн сайт “MongoliaJOL”-д нэгдэн орсон бөгөөд ингэснээр уншигчдын цар хүрээ тэлж, гадаад, дотоодын судлаачид, ургамал сонирхогчид, их дээд сургуулийн оюутан залуус цахимаар манай сэтгүүлийг үзэх боломж бүрдэж байна. Мөн тус сэтгүүл нь ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/14 тушаалаар “Эрдмийн зэрэг, цол хамгаалахад бүтээл хэвлүүлсэнд тооцох Дотоодын эрдэм шинжилгээний бүтээлүүд”-ийн жагсаалтад багтлаа.

Манай хүрээлэнгийн эрхлэн гаргаж буй уг сэтгүүлийн энэ удаагийн дугаарт 10 эрдэм шинжилгээний бүтээл хэвлэгдэж байгаагаас Ургамлын аймаг, ангилалзүйн чиглэлээр-4 өгүүлэл, Ургамалжлын экологи-3, Ургамлын физиологи-1, Ой судлалаар 2 өгүүлэл тус тус байна.

Энэ удаагийн дугаарын Ургамлын аймаг, ангилалзүй бүлэгт ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж буй Хүннүгийн үеийн булш, Төв аймгийн Батсүмбэр суманд орших Ноён уулын булш болон Сүхбаатар аймгийн Онгон сумаас олдсон тарианы харбудуаны цэцгийн доод хайрсны дээжийн ургад хийсэн судалгаа, мөн хагийн төрөл, зүйлээр амьдрах орчны доройтлыг илэрхийлсэн үр дүн болон Монгол-Алтайн уулын хээрийн тойрогт хагийн шинэ цэг бүртгэсэн зэрэг судалгааны үр дүн багтсан бол Ургамалжлын экологи бүлэгт “Хангайн нурууны БЦГ-г бэлчээрийн тогтвортой менежмент хэрэгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт сумын нутагт хийсэн ургамалжлын судалгаагаар 4 хэвшинж, 9 дэд хэвшинжид хамаарах 17 бүлэг эвшлийг ялгаж ангилж, энэхүү ангилааг үндэслэн 1:200000 хэмжээст ургамалжлын зургийг зохиосон судалгаа, мөн Цэнхэр сумын бэлчээрийн төлөв байдал, даац болон бэлчээрийн экосистемийн хангамжийн зарим үйлчилгээний үнэ цэнийг тогтоосон үр дүнгүүд багтлаа.

Хот төлөвлөлтийн тоо нэмэгдэхийн хэрээр хотын ногоон байгууламжийг зөв төлөвлөхөөс гадна түүнд таригдах ургамлын сонголтыг хийхдээ нүүрстөрөгчийн

хийг сайн шингээдэг, стресс хүчин зүйлд дасан зохицох чадвартайг сонгох нь экологи-эдийн засгийн өндөр ач холбогдолтой юм. Та бүхэн Ургамлын физиологийн бүлэгт хэвлэгдсэн “Зарим зүйл модны CO<sub>2</sub> шингээлтийн судалгаа” сэдэвт ногоон байгууламжид өргөн ашиглагддаг мод, сөөг ургамлын CO<sub>2</sub> шингээлтийг тодорхойлсон бүтээлээс дэлгэрүүлэн үзээрэй.

Ой судлал бүлгээс түймэрт нэрвэгдсэн тайгархаг шинэсэн ойн ургамал бүлгэмдлийн өөрчлөгдөл, ойн байгалийн сэргэн ургалтын судалгааны үр дүн, мөн Гмелиний болон Чекановскийн шинэс модны газрын дээрх биомассын аллометрийн тэгшитгэлийг зохиосон судалгааны үр дүнтэй танилцах боломжтой.

Манай сэтгүүлийн мэдээ, мэдээллийн бүлэгт ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн ахмад эрдэмтэн, энэ жил 90 насны ой нь тохиож буй эмийн ургамал судлаач, биологийн ухааны доктор У.Лигаа, хөл газрын ургамал судлаач, шинжлэх ухааны доктор Г.Цэрэнбалжид нарын Ботаникийн шинжлэх ухаан болон сурган хүмүүжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, тэдний бүтээлийн тухай энэхүү дугаарт өгүүлсэн болно.

Сэтгүүлийн ерөнхий редактор, доктор,  
профессор И.Түвшинтогтох

Эрхэм уншигч та бүхэн сэтгүүлийн талаарх болон хэвлэгдсэн өгүүллүүдэд өгөх санал, шүүмжээ доорх хаягаар ирүүлнэ үү.

И-мэйл: [botany@mas.ac.mn](mailto:botany@mas.ac.mn), [mas.botany@gmail.com](mailto:mas.botany@gmail.com)

Шуудангийн хаяг: 13330 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө 54а, ШУА-ийн 1 дүгээр байр, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, 413 тоот

<https://doi.org/10.5564/mjb.v4i30.2578>